



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад дагалдан гарах хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн найруулгын төсөл болон бусад дагалдан гарах хуулийн төслүүдийг 2027 оноос хэрэгжүүлэхээр шаардагдах зардлыг дараах төрөл тус бүрээр тооцлоо:

- Нийгмийн халамжийн санд үүсэх зардал;
- Төрийн байгууллагад үүсэх зардал;
- Хуулийн этгээдэд үүсэх зардал;
- Иргэнд үүсэх зардал.

Түүнчлэн зардлыг тооцохдоо 2025 оны халамжийн сангийн зарцуулалтыг суурь болгон авсан.

А/Нийгмийн халамжийн санд үүсэх зардал

1. Нийгмийн халамжийн амьжиргааг дэмжих тэтгэмж:

Нийгмийн халамжийн тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилготой арга хэмжээ юм.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2026 онд нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сард 478.0 мянган төгрөг, бусад тэтгэврийн хэмжээ 432.0 мянган төгрөг болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр Амьжиргааны доод түшингийн бүсүүдийн дунджийн 90.2 хувьтай тэнцэж байна. Олон улсад шимтгэлд суурилагагүй тэтгэврийн хэмжээ аль болох амьжиргааны доод түшингээс багагүй байдаг байна.

Нийгмийн халамжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн хэмжээ нь 2026 оны байдлаар нийгмийн даатгалын шимтгэлээ 10-аас 20 хүртэл жил төлсөн даатгуулагчийн авч байгаа нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнээс 26.7 хувиар, 20 ба түүнээс дээш жил шимтгэл төлсөн даатгуулагчийн авч байгаа бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс 37.8 хувиар зөрүүтэй буюу бага байна. Гэхдээ нийгмийн даатгалын сангаас олгодог хувь тэнцүүлсэн болон бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс тодорхой хувиар бага байхгүй бол иргэдийн шимтгэл төлөх сонирхлыг бууруулах сөрөг талтай байдаг. Иймд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ нь нийгмийн даатгалын шимтгэлийг удаан хугацаанд төлсөн иргэдийнхээс ялгаатай, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэртэй давхцахгүй, тэтгэврийн төрөл хоорондоо мөн адил давхцахгүй байх зарчмыг баримталсан.

Амьжиргааг дэмжих тэтгэмжийн хэмжээг тооцохдоо ахмад настанд өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд хүүхдийн тоо, өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан тус тус ялгаатай тогтоохоор хуулийн төсөлд тусгасан.

Ахмад настанд олгохоос бусад хүнд олгох халамжийн тэтгэврийн хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түшингийн бүсүүдийн дунджаас багагүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

Одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд олгож байгаа ахмад настны тэтгэврийн насыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт заасан насанд хүрсэн байхаар өөрчилж, өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлэгдсэн өрхийн ахмад настанд олгохоор хуулийн төсөлд тусгасан. Мөн нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн байгууллага, ажилтан нь нийгмийн даатгалын санд тэтгэврийн даатгалын шимтгэл албан журмаар эсхүл сайн дураар төлдөггүй эсхүл төлсөн хугацаа нь нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан хугацаанд хүрэхээргүй байгаа 45 насанд хүрсэн иргэнд ирээдүйд өндөр насны тэтгэвэр авах эрх үүсэхгүй тухай мэдэгдэл, мэдээлэл хүргүүлж, зөвлөгөө өгөх заалтыг нэмж тусгасан.

Одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд олгож байгаа одой иргэний тэтгэврийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэртэй нэгтгэх, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан иргэнд олгох тэтгэврийн хэмжээг 20% нэмэгдүүлж олгохоор тооцов.

Мөн одоо мөрдөгдөж байгаа хуулиар /13.2.4/ эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сар бүр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээгээр амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж олгож байгааг тэтгэврийн нэг төрөл болгон, хуулийн төслийн 7.1.3-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1-д заасан комиссын тодорхойлсон хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд”-д сар бүрийн нийгмийн халамжийн тэтгэвэр олгох зохицуулалтыг оруулсан. Ингэхдээ хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүнд, хөнгөнөөс хамаарч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 20% нэмэгдүүлж олгохоор тооцов.

Одоо мөрдөж буй хуулиар нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын 5 бүлэгт олгож байгааг 4 болгосон. Үүнээс 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт олгох тэтгэврийг хасч өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжтэй нэгтгэсэн ба одоо эрх үүссэн иргэдийн эрх дуусгавар болгох хүртэл хугацаанд олгохоор шилжилтийн үеийн зохицуулалтыг оруулсан.

Нийгмийн халамжийн тэтгэврийн нийт зардлын тооцоо

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар				Хуулийн төсөл хэрэгжсэнээр 2027 оноос		Нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
2023 он		2025 он		НХ-ийн тэтгэврийн хэмжээ /мян.төг/	Хүний тоо	
НХ-ийн тэтгэврийн хэмжээ /мян.төг/	Хүний тоо	НХ-ийн тэтгэврийн хэмжээ /мян.төг/	Хүний тоо			НХ-ийн тэтгэврийн хэмжээ /мян.төг/
375.0	61003	397.5		Ахмад настан 432.0	84556	
2025 оны гүйцэтгэл 242.6 тэрбум.төг				Бусад 478.0		

2. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж:

Одоо мөрдөгдөж байгаа хуульд нийгмийн халамжийн тэтгэмж нь асаргааны тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэний тэтгэмж, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж гэсэн төрөлтэй байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэний тэтгэмжийг хасах, онцгой тохиолдлын тэтгэмжийг зарим төрлийг нийгмийн халамжийн үйлчилгээг хэсэгтэй нэгтгэх, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжтэй нэгтгэх, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон Эхийн алдар одонтой эхийн мөнгөн тусламжийг шинээр боловсруулсан Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд шилжүүлсэн болно.

Асаргааны тэтгэмжийг хүн амын 7 бүлэгт сар бүр олгодог байсан бөгөөд байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний улирлын тэтгэмжийг тэднийг асарч байгаа иргэний тэтгэмжтэй нэгтгэж сар бүр олгохоор тусгасан. 2026 онд дээрх 7 бүлгийн 82806 иргэнд асаргааны тэтгэмж олгоход нийт 307,5 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

Иймд хуулийн төсөлд нийгмийн халамжийн тэтгэмжийг төрөлд хуваахгүйгээр одоогийн асаргааны тэтгэмжийг нийгмийн халамжийн тэтгэмж болгон өөрчилж дээрх 7 бүлгийг 5 бүлэг болгон нэгтгэсэн. Асаргааны тэтгэмжийн хамрах хүрээг ихээр нэмэгдүүлдэг байнгын асаргаа шаардлагатай ахмад настны асарч байгаа иргэний тэтгэмжийг ядуу хэсэгт чиглүүлж зөвхөн ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхийн ахмад болгож өөрчилсөн. Дээрх 82.8 мянган иргэний 44.3 орчим мянга нь зөвхөн ахмад настны асаргаа байгаа юм.

Тиймээс 40 хувь буюу 26553 ахмад настныг асаргааны тэтгэмжид хамрагдахаар тооцсон бөгөөд 17.7 мянган хүн хасагдах юм.

Мөн Нийгмийн халамжийн тухай хуульд заасан өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр болон Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг нэгтгэн нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг төрөл болгон нэгтгэсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэмжийг хүн амын 5 бүлэгт хамруулахаар тусгасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.5-д “18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт сар бүр нийгмийн халамжийн тэтгэвэр олгоно” гэж заасан. Тус арга хэмжээнд 2026 онд 25 иргэн хамрагдаж 129.6 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.4-т заасан 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон эх, эцэг улирал бүр олгодог тэтгэмжид 2026 онд нийт 8966 эх, эцэг хамрагдахаар батлагдсан байна. Тэдгээр иргэнд улирал бүр олгож байгаа 792.0 мянган төгрөгийг сар бүр олгох тохиолдолд 264.0 мянган төгрөг болохоор байгаа бөгөөд энэ хэмжээг бууруулахгүйгээр зохицуулна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийг нэмж хамруулахаар өөрчилсөн ба уг зохицуулалттай холбоотойгоор хамрагдах хүний тоог 20 хувиар нэмэгдэхээр тооцсон.

Хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр тус тэтгэмжид ойролцоогоор 10.8 мянган 0-18 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эх, эцэг хамрагдах боломжтой болох юм.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн нийт зардлын тооцоо

Хуулийн заалт	Хамрагдах хүний тоо	Сар бүр олгох тэтгэмжийн хэмжээ /мян.төг/	Хэмнэгдэх эсхүл нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
8.1.1.нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа;	26553	330.0	(62.2)
8.1.2.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа;	ХБИргэн-16097 ХБХүүхэд-17556	330.0	(5.8)
8.1.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;	374	330.0	-
8.1.4.бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа	2430	330.0	(1.2)
НИЙТ ДҮН	65010		(69.3)
2025 оны гүйцэтгэл: 250.4 тэрбум төгрөг			

Одоогийн хуулийн хүрээнд асаргааны тэтгэмжид хамрагдаж байгаа байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэний 10% нь хувийн туслах үйлчилгээг авахаар тооцов.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээг одоогийн тэтгэмжийн хэмжээгээр тооцов.

Хуулийн төслийн 8.1.1, 8.1.2, 8.1.3-т заасан иргэнд олгох халамжийн тэтгэмжийн хэмжээ нь өрхийн амьжиргааны түвшин, ахмад настны цогц үнэлгээ, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, 8.1.4, 8.1.5-д заасан тэтгэмжийн хэмжээ нь өрхийн амьжиргааны түвшин, хүүхдийн тооноос хамаарч тус тус ялгаатай байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжид 7.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг нэгтгэснээр одоогийн хуулиар байнгын асаргаа шаардлагатай иргэнд сар бүр олгож байгаа тэтгэмж, улирлын тэтгэмжийн хүрээнд нэг өрхөд очиж байсан зардал буурахгүй бөгөөд цаашид нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд нэмэгдэх боломжтой болох юм.

3. Нийгмийн халамжийн дэмжлэг:

Хуулийн төслийн “Нийгмийн халамжийн дэмжлэг” гэсэн 3 дугаар бүлэгт хүнс тэжээлийн, боловсролын, эрүүл мэндийн гэсэн 3 төрлийн дэмжлэг байхаар тусгасан.

Өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхөд түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа түлш худалдан авах эрхийн бичиг эсхүл мөнгөн тусламж олгохоор заасан ба хамрагдах хүний тоог одоогийн Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа 17.0 мянган өрхийг хамрагдахаар, мөнгөн дүнг 250.0 мянган төгрөг байхаар тооцов.

Одоогийн Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4-т заасан аргачлалаар тогтоосон тарифыг үргэлжлүүлэн мөрдөхөөр тооцов.

Хуулийн заалт	Хамрагдах өрхийн тоо	Сар бүр олгох тэтгэмжийн хэмжээ /мян.төг/	Хэмнэгдэх эсхүл нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхөд олгох түлш худалдан авах эрхийн бичиг эсхүл мөнгөн тусламж	17000	250.0	4.3
НИЙТ ДҮН			4.3

Энэ зардал нь хуулийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан ба нэг аймагт 100.0 орчим сая төгрөг ногдох бөгөөд орон нутаг бүр өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх боломжтой. Нийслэлийн хувьд хүн амын тооноос хамааран 1.3 орчим тэрбум төгрөг зарцуулах юм.

3.1. Хүнс тэжээлийн дэмжлэг:

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнээс бусад иргэнийг хамруулахаар хуулийн төсөлд тусгасан. 2025 онд хамрагдсан 22.8 мянган хөдөлмөрийн насны иргэн байна. Үүнээс жирэмсэн болон бага насны хүүхэдтэй эхчүүд, их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа зэрэгт хамаарахгүй байхаар заасан.

Нэг өрхийн хамрагдах хугацааг 24 сар байхаар зааж, хуулийн төсөлд 13.3-т хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах, хүүхдээ товллын дагуу заавал хийх дархлаажуулалтад бүрэн хамруулах, сургуулийн насны хүүхдээ албан эсхүл албан бус боловсролд бүрэн хамруулж, хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг биелүүлэхээр заасан. Эдгээр нөхцөлийг биелүүлсэн эсэхээс шалтгаалж сунгах эсэхийг шийдвэрлэхээр заасан.

Хуулийн заалт	Хамрагдах хүний тоо	Сар бүр олгох тэтгэмжийн хэмжээ /төгрөг/	Хэмнэгдэх эсхүл нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнээс бусад иргэн	106157	Хүүхэд 16,000 Том хүн 16,000	(4.4)
НИЙТ ДҮН	106157		14.4
2026 оны төсөв: 18.8 тэрбум төгрөг			

3.2. Сургалтын байгууллагад суралцагчид үзүүлэх дэмжлэг:

Нийгмийн халамжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа зорилтот бүлгийн хүүхдэд хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт олгохоор тусгасан байдаг ч төсөв хөрөнгөөс шалтгаалан өнөөг хүртэл хэрэгжээгүй.

Магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, коллежид суралцаж байгаа бүтэн өнчин болон Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан суралцагчид хичээлийн жилийн 9 сарын хугацаанд улиралд нэг удаа амьжиргааны доод түвшинтэй тэнцүү хэмжээний амьжиргааны зардлын дэмжлэгийг нийгмийн халамжийн сангаас олгохоор тусгасан. Амьжиргааны зардлыг хичээлийн 9 сарын хугацаанд улиралд нэг удаа 450.0 мянган төгрөгөөр тооцон олгохоор зардлын тооцоонд тусгав.

Хууль хэрэгжиж эхэлснээр зорилтот бүлгийн хүүхдийн сургууль завсардалт буурч, өрхийн амьжиргаанд зохих дэмжлэг болно.

Нийгмийн халамжийн тухай хууль		Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл			Хэмнэгдэх эсхүл нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
20 дугаар зүйл. Боловсролыг дэмжих үйлчилгээ (Хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт)		14 дүгээр зүйл. Боловсролын дэмжлэг			
Хамрагдсан хүүхдийн тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хамрагдах хүүхдийн тоо	Нэг хүүхдэд олгох амьжиргааны зардлын дүн /мян.төг/	Зарцуулах хөрөнгө /тэрбум.төг/	0.4
0	0.0	300	450.0	0.4	
Улсын төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан тус арга хэмжээ хэрэгжихгүй байна.					

Боловсролын дэмжлэгийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны үнийн болон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11.8-д заасан төлбөрийн дэмжлэгийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан хэрэгжүүлэхээр заасан.

3.3. Эрүүл мэндийн дэмжлэг

Одоогийн хуулиар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцаж байгаа зохицуулалт хэвээр үргэлжилнэ.

Мөн уг өрхийн 0-6 хүртэлх насны хүүхдэд нэн шаардлагатай эм, бичил тэжээл, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгахаар заасан.

Эмзэг бүлгийн өрх, иргэдийг чадавхижуулах, хөдөлмөр эрхлүүлэх чиглэлийн үйлчилгээг энэ хуульд шинээр бий болгож байгаа ч архины хамааралтай гишүүдийг эмчлэхгүйгээр тэдгээр өрхтэй ажиллахад үр дүн төдийлөн гарахгүй. Түүнчлэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд архины донтолтыг бууруулах эмчилгээ байдаг боловч ихэнхдээ төлбөртэй байдаг учраас ар гэр нь боломжтой иргэд төлбөрөө төлж хамрагддаг байна. Мөн эм нь үнэ өндөр учраас авах боломж бололцоо эмзэг бүлгийн өрхийн хувьд боломжгүй юм.

Уг дэмжлэгт хамрагдах өрх, иргэнийг нийгмийн халамжийн байгууллага хариуцан тодорхойлж, холбогдох зардлыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвөөс хариуцахаар тусгасан.

4. Нийгмийн халамжийн үйлчилгээ

Хуулийн төслийн “Нийгмийн халамжийн үйлчилгээ” гэсэн 4 дүгээр бүлэгт бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ, кейс менежментэд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээ, асрамжийн үйлчилгээ, гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ гэсэн 4 төрөлтэй байхаар тусгасан.

Улс орнуудын нийгмийн халамжийн тогтолцоо нь бэлэн мөнгөний болон бэлэн мөнгөний бус үйлчилгээ нь ижил түвшинд байдаг байна. Гэтэл манай улсын хувьд дийлэнх нь бэлэн мөнгөний хөтөлбөр, нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж байгаа зардал нь нийт зардлын 1 хувьд ч хүрэхгүй байна. Үйлчилгээг хэрэгжүүлэх явцад иргэн, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, зорилтот бүлгүүдийн нийгмийн оролцоо дээшилсэн боловч аймаг, орон нутагт төрийн бус байгууллагын тоо бага, чадавх сул, үйлчилгээний чанарт хяналт дутмаг байгаагаас үйлчилгээ жигд хэрэгжихгүй байгаагаас төсөв хөрөнгө багассаар жилдээ 1.0 тэрбум гаруй төгрөг зарцуулж байна.

Тиймээс хуулийн төсөлд нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхижуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал: Зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхижуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг орон нутгийн оролцоотойгоор хэрэгжүүлэхээр тусгасан.

Нийгмийн халамжийн үйлчилгээг эмзэг хэсэгт чиглүүлж тэдний зан үйл хандлагыг өөрчлөх, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, ажилтай орлоготой болоход чиглэсэн

үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхээр тусгав. Мөн тэдгээр өрх иргэнтэй ажиллахад орон нутгийн байгууллага иргэний үүрэг оролцоог тодорхойлж өгөв. Нийгмийн ажилтнууд эмзэг бүлгийн айл, өрхөөрөө тойрч асуудлыг нь олж шийдвэрлэж нийгмийн ажлын үйлчилгээгээ үзүүлэхээр зохицуулсан.

Хуулийн заалт	Нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Асрамжийн үйлчилгээ /орон нутаг хамт/	5.6
Бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны цогц үйлчилгээ	20.0
Кейс менежментэд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээ	20.0
Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ	
НИЙТ ДҮН	45.6

Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг үйлчилгээ тус бүрд 20.0 тэрбум төгрөг байхаар зардлын тооцоог хийв.

5. Нийгмийн халамжийн хуулийн хүрээнд олгож байсан зарим тэтгэвэр, тэтгэмжийн нэгтгэх, хассанаар хэмнэгдэх зардал

Хуулийн заалт	Хамрагдах хүний тоо	Сар бүр олгох тэтгэмжийн хэмжээ /мян.төг/	Хэмнэгдэх хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Ахмад настны тэтгэвэр /босго шугамаас доогуур амьжиргаатайд олгох/	2278	432.0	11.3
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр	25	432.0	0.1
Ахмад настны асаргааны тэтгэмж /босго шугамаас доогуур амьжиргаатайд олгох/	17702	330.0	62.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны тэтгэмж /хувийн туслах үйлчилгээнд хамрагдах/	1789	330.	5.8
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	76658	60.0 /улирал бүр 478.0 /сар бүр/	78.6
Онцгой тохиолдлын тэтгэмж	1169	1200.0 /нэг удаа/	1.4
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	22810	Том хүн 20.0 Хүүхэд 12.0	4.4
НИЙТ ДҮН	122431		(175.1)

6. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах хуулийн төслүүдтэй холбоотой тэтгэвэр, тэтгэмж:

6.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламж:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу Нийгмийн халамжийн сангаас 13 төрлийн тусламж, хөнгөлөлтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байна. Эдгээр тусламж үйлчилгээнд 2026 онд 59.3 мянган хүнд, 15.7 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Дээрх нэр төрлийн тусламж, хөнгөлөлтөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамгийн их хамрагддаг түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлтөд 3.9 тэрбум төгрөг, протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд 4.9 тэрбум төгрөг, дотоодын рашаан сувиллын хөнгөлөлтөд 1.2 тэрбум төгрөг тус тус зарцуулсан нь нийт зардлын 60 гаруй хувийг эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдах эсэхийг Эмнэлэг хяналтын комисс, сумын эмч нар тодорхойлж байна. Нийгмийн халамжийн байгууллага протез, ортопедийн болон тусгай хэрэгсэл үйлдвэрлэж, нийлүүлдэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээт байгууллагын ихэнх нь нь эрүүл мэндийн чиглэлийн байгууллага буюу эм ханган нийлүүлэх байгууллагууд байна.

Нийгмийн халамжийн байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг протез, ортопедийн болон тусгай хэрэгсэл нийлүүлдэг байгууллагаас иргэдэд олгосон бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангахгүй, хэрэгцээгүй байгаа талаар гомдол халамжийн байгууллагад байнга ирдэг байна. Зарим аймагт нийлүүлэгч байгууллагууд сумдуудаар тойрч ортопед, тусгай хэрэгслийг тараах асуудлыг гаргасаар байна. Энэ нь нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний заалтыг зөрчиж байгаа бөгөөд хяналт, хариуцлагын тогтолцоо муу байгааг харуулж байна.

Халамжийн байгууллага эмнэлгийн байгууллагын тодорхойлолт баримт бичгийг үндэслэн зөвхөн санхүүжилт олгож, хяналт хийхдээ тухайн иргэн шаардлагатай ортопед, тусгай хэрэгслээ авсан эсэх, ашиглаж байгаа эсэх, асуудал үүссэн зэргийг хянаж, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн, тусгай хэрэгсэл нийлүүлсэн байгууллагын гэрээг цуцлах арга хэмжээ авахаас хэтрэхгүй байгаа ба энэ төрлийн хэрэгслийн чанар стандарт, эдэлгээний хугацаа, тухайн хүнд тохирох эсэх зэрэг мэргэжлийн чиглэлийн нарийн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна. Тиймээс цаашдаа энэ төрлийн үйлчилгээнд мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай бол эрүүл мэндийн байгууллагад төсөв хөрөнгөтэй нь шилжүүлэх, зарим арга хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлдэг үйлчилгээтэй уялдуулах шаардлагатай байна.

ЭМД-ын санд шилжүүлэх зардал:

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар олгож байгаа тусламж хөнгөлөлт	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хуулийн төсөлд туссан байдал	ХС-аас шилжүүлэх зардлын хэмжээ /тэрбум.төг/
18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 2 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох			Санхүүжилтийг ЭМД-ын сангаас олгохоор хуулийн төсөлд тусгасан.	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	2541	0.55	Санхүүжилтийг ЭМД-ын сангаас олгохоор хуулийн төсөлд тусгасан.	(0.55)

18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан болон ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох	9721	4,3	Санхүүжилтийг ЭМД-ын сангаас олгохоор хуулийн төсөлд тусгасан.	(4.3)
Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	3862	1,2	Санхүүжилтийг ЭМД-ын сангаас олгохоор хуулийн төсөлд тусгасан. /Шинэ хуулиар 1500 хүн нэмэгдэхээр тооцов./	(1.2)
НИЙТ ДҮН	16124	6.05		(6.05)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33.4-т заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүн олимп, паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно.” гэсэн заалтыг өөрчилж Засгийн газраас олгох шагнал урамшуулалтай нэгтгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэртэй нэгтгэсэн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1, 26.1.6, дахь заалтад заасан тусламж, хөнгөлөлтийн зардлаас хэмнэгдсэн зардлыг шинэ хуулийн төсөлд нийгмийн халамжийн тэтгэврийн зардалд нэмсэн.

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар олгож байгаа тусламж хөнгөлөлт	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хэмнэгдэх зардлын хэмжээ /тэрбум.төг/
Бүрэн хараагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	28362	3.9	(3.9)
Бүрэн хэлгүй дүлий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох			
Одой иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох			

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох			
18 насанд хүрсэн бүрэн хараагүй, бүрэн сонсголгүй болон хэл ярианы бэрхшээлтэй иргэний харилцаа, холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх	4428	1.1	(1.1)
Нийт	32790	5.0	(5.0)

Нэмэгдэх зардал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх гэж тусгасныг хуулийн төсөлд хөгжлийн төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа 2000 хүүхдийг шинээр нэмж хамруулахаар тусгасан ба уг зардалд 0.4 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар тооцов.

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар олгож байгаа тусламж хөнгөлөлт	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хуулийн төсөлд туссан байдал	Нэмэгдэх зардлын хэмжээ /тэрбум.төг/
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх	7933	1.6	Хөгжлийн төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийг шинээр нэмж хамруулна.	1.6

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.14 дэх заалт “хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайл хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх” мөн хараагүй хүнд зориулсан брайл болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах үйлчилгээг шинэ хуулиар хассан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх өдрийн, явуулын, гэрийн, сайн дурын, түр болон урт хугацаагаар асрах үйлчилгээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэн иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэхээр шинэ хуулийн төсөлд тусгасан. Энэ үйлчилгээг 5000 хүнд хүргэж, 5.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.9, 26.1.10, 26.1.11, 26.1.12, 26.1.13, 26.1.15 дахь заалтад заасан үйлчилгээ тус бүрийг шинэ хуулиар өөрчлөхгүй хэвээр үлдээв.

Хэвээр үргэлжлэх тусламж, хөнгөлөлтүүд:

Үйлчилгээний төрөл /Одоогийн хуулиар/	Олгосон хүний тоо	Олгосон мөнгөн дүн (тэрбум. төг)
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	-	-
Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	937	0.33
Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болбол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	17	0.06
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох	74	0.02
Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тусламж олгох	1262	2.5
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадалгаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол төлбөрийн 70 хувь нөхөн олгох	-	-
Нийт	2290	2.91

6.2.Ахмад настанд олгох дэмжлэг, хөнгөлөлт:

Протез, ортопед болон тэргэнцэр, нэн шаардлагатай тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ижил үндэслэлээр ЭМД-ын санд шилжүүлэхээр тусгасан.

Харьяалалгүй ахмад настанд олгох хүндэтгэлд 2015 онд 38.0 мянган ахмад хамрагдаж 708.0 сая төгрөгийн зардал гардаг байсан бол сүүлийн жилүүдэд орон нутагт улс төрийн зорилгоор хэрэгжүүлэх болсноос 2016 оноос хойш 100.0 мянга гаруй ахмад хамрагдаж зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1.4-1.7 тэрбум төгрөг болтлоо нэмэгдээд байна. Тиймээс уг зардлыг нийгмийн халамжийн сангаас хасаж, санхүүжилтийг аймаг, нийслэлийн Засаг даргын төсвөөс хариуцахаар зохицуулсан.

Эрүүл мэндийн даатгалын сан болон улс, орон нутгийн төсөвт шилжүүлэх зардал:

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар олгож байгаа тусламж хөнгөлөлт	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хуулийн төсөлд туссан байдал	Зөрүү /хэмнэгдэх эсхүл нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ/
Хөл, гар, шүд/үнэт металлаар хийхээс бусад/-ний протезын хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутамд нэг удаа нөхөн олгох	28839	2.2	Санхүүжилтийг ЭМД-ын сангаас олгохоор хуулийн төсөлд тусгасан.	(2.2)
Сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон	16624	3.2	Санхүүжилтийг ЭМД-ын сангаас	

дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн олгох			олгохоор хуулийн төсөлд тусгасан.	(3.2)
Эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	50065	5.9		(5.9)
Хүндэт донор ахмад настан дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	793	0.62		(0.62)
Ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл	147956	2.8	НХС-аас хасч орон нутгийн төсөвт шилжүүлсэн.	(2.8)
Нийт	244277	14.72		(14.72)

6.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож байсан зарим дэмжлэг, тусламж, хөнгөлөлтийг нэгтгэснээр хэмнэгдэх зардал:

Одоо үзүүлж байгаа ахмадын амралт, сувиллын эрхийн бичгийн хөнгөлөлтийг шинэ хуулиар сувиллыг нь магадлан итгэмжлэгдсэн сувилалтай нэгтгэсэн. Харин амралтыг нь ахмадын зориулалттай болгож идэвхтэй насжилтын үйлчилгээтэй уялдуулж, стандартыг сайжруулна. Ингэснээр хамрагдах хүний хүний тоо 12625 болж бууран зарцуулах хөрөнгийн хэмжээ 2.8 тэрбум төгрөг хэмнэгдэхээр байна.

Хуулийн заалт	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг /	Шинээр хамрагдах хүний тоо	Хэмнэгдэх хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох	63125	13.8	12625	(11.04)
НИЙТ ДҮН				

6.4. Үйлчилгээг сайжруулахын тулд төсвийг нэмэгдүүлэхээр тооцсон.

Хуулийн заалт	Хамрагдсан хүний тоо	Хамрагдах хүний тоо	Нэмэгдэх хөрөнгийн хэмжээ /тэрбум.төг/
Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ	109108	109108	0.0
НИЙТ ДҮН			

Насжилт нэмэгдэж байгаатай холбогдуулан Ахмад настны тухай хуулийн өөрчлөлтөөр ахмад настанд чиглэсэн төрөл бүрийн үйлчилгээг хөгжүүлэхээр заасан бөгөөд уг үйлчилгээнд 30.0 мянган ахмад настан хамрагдахаар тооцсон.

6.5.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд түлшний үнийн дэмжлэг олгохоор зохицуулсан.

Хуулийн заалт	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хэмнэгдэх хөрөнгийн хэмжээ /сая.төг/
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	4936	0.41	(0.41)
Хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	1370	0.17	(0.17)
Нийт	6306	0.58	(0.58)

Түлшний үнийн дэмжлэгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд тусгасан бөгөөд Өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрх эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхөд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр түлш олгох арга хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан журмын дагуу хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан.

6.6. Хэвээр үлдээсэн болон орон нутгийн төсвөөс хариуцах үйлчилгээнүүд

Хуулийн заалт	Хамрагдах хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Тайлбар
НД-ын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тусламж олгох	619	0.82	Өөрчлөлтгүй хэвээр үлдээсэн
Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	2284	0.24	Өөрчлөлтгүй хэвээр үлдээсэн
НИЙТ ДҮН	2903	1.06	

Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл бусад дагалдах хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр халамжийн санд үүсэх зардлын нэгдсэн тооцоо

№	Төрөл /Одоогийн/	Төрөл /Хуулийн төсөлд/	2026 оны төсвөөр		ШИНЭ ХУУЛИАР		НЭМЭГДЭХ, ХАСАГДАХ	
			Хүний тоо	Зардал (тэрбум. төг)	Хүний тоо	Зардал (тэрбум. төг)	Хүний тоо	Зардал (тэрбум. төг)
1	Халамжийн тэтгэвэр	Халамжийн тэтгэвэр	61573	345.9	84556	471.0	(22983)	125.1
2	Асаргааны тэтгэмж	Асаргааны тэтгэмж	82.806	307,5	65.010	246,2	(17.797)	(61,4)
3	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж		77.827	78,6	-	-	(77.827)	(78,6)
4	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	Хүнс тэжээлийн дэмжлэг	128.967	18,8	106.157	14,4	(22.810)	(4,4)
5	Боловсролыг дэмжих үйлчилгээ	Сургалтын байгууллагад суралцагчид үзүүлэх дэмжлэг;	-	-	300	0.4	300	0.4
6	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	Эрүүл мэндийн дэмжлэг	-	-	-	-	-	-
7	Асрамжийн үйлчилгээ	Асрамжийн үйлчилгээ	670	5,6	670	14.0	-	-
8		Бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ				20.0	-	-
9		Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ				20.0	-	-
10	ОНОТХүйлчилгээ /ОНТөсөв/		9042	3.0	-	-	9042	(3.0)
11	Ахмад настны хөнгөлөлт, тусламж	Ахмад настны хөнгөлөлт, тусламж	488.115	65,96	334.988	42,42	(153.127)	(23,54)
12	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдлийн тухай		4.064	0,82	-	-	(4.064)	(0,82)
13	ХБ-тэй иргэний хөнгөлөлт тусламж	ХБ-тэй иргэний хөнгөлөлт тусламж	59.252	15,70	16.637	9,20	(42.591)	(6,38)
	ДҮН		912.316	841,9	625.318	841,9	(286.998)	(0,00)

Нийгмийн халамжийн нийт 40 төрлийн үйлчилгээнээс өөрчилж, нэгтгэх, зарим төрлийн үйлчилгээг шинээр нэмснээр 25 төрлийн үйлчилгээтэй байхаар хуулийн төсөлд тусгасан. Нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах хүний тоо 287.0 мянган иргэнээр

буурч, зардал хэвээр байна. Хүний тоо буурч байгаа нь зарим үйлчилгээг эрүүл мэндийн байгууллага зэрэг бусад салбарт шилжүүлсэнтэй холбоотой.

Б/Төрийн байгууллагад үүсэх зардал

1. Төрийн байгууллагад шинээр үүссэн үүрэгтэй холбоотой гарах зардал:

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд, бүх шатны Засаг дарга, нийгмийн халамжийн ажилтнууд үүрэг оноосон зохицуулалт тусгасан. Үүнээс Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд, нийгмийн халамжийн ажилтнуудад үүрэг оноосон зохицуулалт Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулагдаж ирсэн бөгөөд ихэнх зохицуулалт нь шинэ эрх, үүрэг үүсгээгүй болно. Харин хуулийн төсөлд (нийгмийн ажилтан, төрийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл), бүх шатны Засаг дарга нарт шинээр нэмж үүрэг оноосон.

1.1. Үүрэг хүлээх байгууллагууд болон тэдгээрийн гүйцэтгэх үүргүүд

Хуулийн төслөөс хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэж, зардал үүсгэх заалтуудыг түүвэрлэн доорх хүснэгтэд оруулан шинжлэв:

Хуулиар тогтоох үүрэг

Д/д	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Холбогдох зүйл заалт	Гүйцэтгэх үүрэг
1.	Бүх шатны Засаг дарга нар	<p>34.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан нутаг дэвсгэрийн хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>34.2.Энэ хуулийн 34.1-д заасан зорилтыг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж, санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.</p> <p>34.3.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь энэ хуулийн 34.1-д заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр нийгмийн бусад үйлчилгээнд зорилтот өрх, иргэнийг тэргүүн ээлжид хамруулна.</p> <p>34.4.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь тухайн орон нутгийн зорилтот өрх, иргэнд энэ хуулийн 16.1-д заасан үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтанд дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>34.5.Сум, дүүрэг, баг хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн 16.1-д заасан үйлчилгээг үзүүлэхэд иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх байр болон хууль тогтоомжид заасны дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</p> <p>34.6.Баг, хорооны Засаг дарга нь зорилтот өрх, иргэнийг үнэн зөв тодорхойлж нийгмийн халамжийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>- Ядуурал, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, баг хорооны Засаг дарга нартай хамтран ажиллах;</p> <p>- Ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын оролцоо, санал санаачилгыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах.</p>

1.2. Гарах зардлыг тооцох

Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд аймаг, дүүрэг, сум хорооны ажилтнуудыг орон нутагт шууд харьяалуулахаар тусгасан.

Тухайлбал:

- Аймаг, дүүргийн Засаг дарга нь тухайн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн;
- Сумын Засаг дарга нь сумын халамжийн нийгмийн ажилтныг тухайн аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн;
- Дүүргийн Засаг дарга нь хорооны халамжийн нийгмийн ажилтныг тухайн дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн томилохоор тус тус заасан.

Мөн шинээр орон тоо нэмэхгүй учир зардал нэмэгдэхгүй. Улсын байцаагчдын хувьд Улсын мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой ажиллаж байгаа байцаагчид ажиллах тул орон тоо нэмэгдэж зардал гарахгүй.

Эрүүл мэндийн даатгалын санд Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протезын хэрэгсэл, магадлан итгэмжлэгдсэн сувиллын үнийн хөнгөлөлтийг шилжүүлэх тул мөн нэмж зардал гарахгүй.

Харин Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн согтуурах мансуурах донтой иргэнийг донтолтоос ангижруулах эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээнд зуучлан хамруулах, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн засал, сургалтад хамруулах, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ болон гэр оронгүй оршин суух тодорхой газаргүй өрх, иргэнийг илрүүлэх, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээний зардлыг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 33.1-д заасан сангаас буюу архидан согтуурахтай тэмцэх сангаас санхүүжүүлэхээр тусгасан. Энэ сангаас жилд 5.0 орчим тэрбум төгрөг нийгмийн халамжийн санд шилжүүлэн тусгах шаардлагатай болно.

Мөн нийгмийн халамжийн үйлчилгээний зардлын 50 хувийг улсын төсвөөс, үлдсэн 50 хувийг орон нутгийн төсвөөс тус тус нийгмийн халамжийн санд төвлөрүүлэн санхүүжүүлнэ гэж заасан тул аймаг, нийслэлийн төсвөөс буюу орон нутгийн төсвөөс нийтдээ 30.0 орчим тэрбум төгрөг зарцуулна.

В/Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 33 дугаар зүйлд “Иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг”-ийг шинээр тусгасан.

33.1.Нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа зорилтот өрх, иргэн дараах үүргийг хүлээнэ:

33.1.1.өрхөд шинээр хүүхэд төрсөн, үрчлэн авсан, өрхийн гишүүн нас барсан, эсхүл шилжиж ам бүлийн тоонд өөрчлөлт орсон бол сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэнд 14 хоногийн дотор мэдэгдэх;

33.1.2.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдахдаа нийгмийн халамжийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шалгуурыг хангаж байгаа эсэхээ үнэн зөв мэдээлэх;

33.1.3.орон нутгаас зохион байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн болон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох.

33.2.Иргэн нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах шаардлагатай зорилтот өрх, иргэний талаар мэдсэн тохиолдолд тухайн орон нутгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн мэргэжилтэн, нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

33.3.Иргэн, хуулийн этгээд нь нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот өрх, иргэнд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж, дэмжлэг үзүүлж болно.

33.4.Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэл, татвар, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зэрэг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийгмийн халамжид хамрагдах зорилгоор амьжиргааны түвшнээ үнэлүүлэх хүсэлт гаргасан өрх, иргэний холбогдох мэдээллийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр үнэ төлбөргүй, шуурхай гаргаж өгөх, мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

Тус заалт нь иргэн, хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилготой бөгөөд тус заалтыг иргэн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх тул эдгээрт үүсэх зардлыг тооцох боломжгүй юм.

---oOo---